

«Монголын тухай судлал» сэтгүүлийн эхний дугаарт манай улсын эрдэмтдийн бүтээлээс, тухайлбал Д. Цэрэнсодном, Г. Сүрэнжав нарын бичсэн «Хятадын уран зохиол монгол нутагт аман зохиолоор дэлгэрсэн нь», «БНМАУ-ын шинжлэх ухаан техникийн хөгжил, түүний онцлог» өгүүллүүдийг орчуулан тавьжээ.

Сэтгүүлийн «Хүмүүс» буланд манай орчин үеийн уран зохиолын үндэс суурийг тавилцсан их зохиолч Д. Нацагдорж, С. Буяннэмэх нарын амьдрал, уран бүтээл, Монголын хөгжмийн нэрт зохиолчдын товч намтар, зохиол бүтээлийн тухай өгүүлэл, танилцуулга оржээ.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, хүн ардын зан заншлын тухай танилцуулах «Байгаль орчин, зан заншил» буланд эртний Монголын нийслэл Хархорум, тал нутгийн цэнхэр сувд-Хөвсгөл нуурын тухай материал хэвлэгдсэн байна.

Сэтгүүлийн төгсгөлд «Монголын түүх, соёлын дурсгал» (Д. Майдар М., 1982 номын танилцуулга оруулжээ.

«Монголын тухай судлал» сэтгүүл БНХАУ-д хэвлэгдэх болсон нь дэлхийн монгол судлалын цар хүрээ тэлж, судлаачдын эгнээ өргөжин байгаагийн нэг илрэл бөгөөд Монгол, Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн хөрш орны ард түмнүүд бие биеэ ойлгон, социалист байгуулалтын ололт амжилт, арга туршлагаа харилцан үзэж танилцахад сайхан бололцоо олгож байна.

Д. Шүрхүү

**НЬЮ-ЙОРК-ВАШИНГТОН-
ПРИНСТОН**
(Замын тэмдэглэл)

Доктор Ш.САНДАГ

Монгол орны маань зуны аагим халуун өдөр үргэлжилнэ. Анхны ногоо соёолж, хөхрөн ягаарах униар татсан Монгол нутаг маань юутай сайхан. Улаанбаатар дээгүүр хөглөгөр үүлс хуран цугларч, хур бороо нэлээд сууж орох янзтай дуслал нь алс холын Америкийг зорьсон бидний «алтан шарга» зам саадгүй байна гэж шивнэж байгаа юм шиг бодол төрүүлнэ. Хуртай жил болж, дэлгэр зун ирж, хөдөө тал маань сэргэж тэнүүн сайхан болох нь гэж баярлахын сацуу холын замын алжаалыг санаж эрхгүй бага зүрхшээнэ...

Тэгээд зуны тэр нэгэн өлзийт сайн өдөр БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Н. Содном тэргүүтэй төлөөлөгчид бид АНУ-ын шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн америкийн зөвлөлийн (ЭЙСИЛСИ) урилгаар АНУ-д албан ёсны зочлолт хийхээр одсон билээ.

Бид ниссээр Москва орж, тэнд АНУ-ын элчин сайдын яаманд виз мэдүүлсэнд ашгүй түргэн бүтэж, цааш аян замаа үргэлжлүүлэх боллоо.

Замд бидний хэргийг бүтээхэд Москва дахь манай элчин сайдын яамны зөвлөх Ж. Энхсайхан ихэд тусалсанд баярлаж явав.

Энэ үес ЗХУ-д ид өрнөж байгаа гайхамшигт өөрчлөн байгуулалт Аэрофлотыг хамарч Пан-америкэн хэмээх нисэх онгоцны асар том кампанитай хамтран Нью-Йорк-Москвагийн хооронд долоо хоногт гурван удаа нислэг хийх болсон байсан тул бид өрнө зүг Пан-америкэн кампаний Боинг-747 онгоцоор нислээ. Ийм онгоцоор урьд нисч явсан бидэнд энэ асар том онгоцны үйлчилгээ урьдын адил онц сайн, гагцхүү үйлчлэгч багийн тал нь америкчууд, тал нь зөвлөлтийнх болсон ажээ.

Бид ингэж аян замаа үргэлжлүүлж Европыг өнгөрч, төдхөн догшин Атлантын их далай дээгүүр өрнө зүг арваад цаг ниссээр байхад дор маань салхигүй тул далай давалгаагүй, намуун дөлгөөн хөхрөн харагдаж, алс тэртээд номин тэнгэрийн хаяатай нийлэх мэт харагдана. Алсыг зорьсон бидний аян зам ийнхүү өлзийтэй үргэлжилж, хэдэн цаг өнгөрсний дараа Нью-Йоркийн Кеннедийн нэрэмжит онгоцны буудалд амар мэнд буулаа.

Биднийг АНУ-ын олон улсын судалгаа шинжилгээ ба солилцоо эрхэлсэн газрын (АЙРЕКС) орлогч захирал Д. С. Матушевски, Индианы их сургуулиас бидэнтэй нүүр учрахаар ирсэн нэрт монголч эрдэмтэн Х. Гомбожав нар угтан авч, 6-7 алхам урт нэгэн урт суудлын машинд суулгаж Нью-Йорк хотын зүг одлоо.

Нью-Йорк хуучин янзаараа хөл үймээн, нүр их чимээ шуугиантай. Хүн хар ийш тийшээ сүлжилдэж, тоолж барашгүй хэв загварын олон автомашин үерийн ус адил урсана. Тэнгэр хадсан өндөр байшингууд хөл үймээнт гудамжны хоёр талаар зэрэгцэн сүндэрлэсэн нь гайхамшигтай бөгөөд сүр жавхлантайг үгээр илэрхийлэхийн аргагүй мэт. Гагцхүү нүдээр үзэх хэрэгтэй аж.

Үүний өмнө саявтархан манай эрхэм зохиолч, эрдэмтэн Л. Түдэв «Нью-Йорк-урт чацтай хот» гэсэн том өгүүллийг «Үнэн» сонинд нийтлүүлж, Америкийн энэ асар том хотын тухай олон сонин зүйлийг бичиж, уншигчдын анхааралд толилуулсан нь энэ тухай бидний өгүүлэхийг өчүүхэн ч хомсдуулсангүй. Учир нь хүн бүр өөр өөр нүдээр үзэж, өөр өөр сэтгэдэг тул билээ.

Одоо ч ил тод, шулуун шударга байх ёс, шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын уур амьсгал орон орноор үл барам, олон улсын амьдралд нэвтэрч байгаа нөхцөлд өөр өөрөөр сэтгэж, өөр өөр үзэл баримтлалаа хар шуулан үзэж, үнэний мөрийг олох тэмүүлэл газар авч байна.

Энэ тухай хойно бичих тул энд эс өгүүлэн өгүүлэх нь: бид Америкт байх хугацаандаа тэндэхийн эрдэмтэд, төрийн ба олон нийтийн зүтгэлтэнтэй уулзаж, ажил хэргээ ярилцан, санал бодлоо солилцлоо. Юуны өмнө нэрлэхэд, сенатор А. Крэнстон, манай Монголд АНУ-аас суухаар томилогдсон Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Р. Уильямс, АНУ-ын шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн зөвлөлийн (ЭЙСИЛСИ) ерөнхийлөгч Стэнли Катц, АЙРЕКС-ын захирал А. Кассоф нарыг хэлж болно.

Бид Нью-Йорк, Вашингтон, Нью-Жерси муж улсын Принстон хотоор явж, шинжлэх ухааны байгууллагуудын ажилтай танилцахад хаа ч очсон, хэнтэй ч уулзсан биднийг америкчууд их л хүндэтгэн хүлээн авч, зочлон, найрсгаар ярилцах ажээ.

Урьд цагийн хатууд, «хүйтэн дайны» үед монгол, америк хүн ингэж найрсгаар ярилцах байтугай, уулзаж учрах ч хэцүү байсан биз ээ. Одоо болохоор цаг улирал өөр болж, олон улсын байдал хурц түгшүүртэй

байснаа нааштай үйл явцын дүнд намжих тийш хандсаны бас нэг илрэл болуу.

Хүн төрөлхтөн уул хад мэт овоолсоор байх цөмийн зэвсгээс үнэхээр залхлаа. Цөмийн болон бусад зэвсгийг хорогдуулан устгая гэсэн хоосон үг сонссоор хашрав. Манай дэлхий, хүн төрөлхтний хувь заяаг зөнд нь хаяж болохгүйг хүн бүр ухамсарлах цаг болжээ. Ингээд ч цөмийн эсрэг өргөн олон нийтийн хөдөлгөөн дэлхий даяар өрнөж байна. Энэ хөдөлгөөний тэргүүнд ЗХУ болон социалист бусад орон явж байна. Цөмийн дайны аюулыг зайлуулах, цөмийн зэвсэглэл хорогдуулахын төлөө ЗХУКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын тавьж буй асар их хүчин чармайлтыг дэлхий дахин өндрөөр үнэлж байна.

Дэлхийн улс түмэн эсэн мэнд байж, харилцан ойлголцож, хамтран ажиллахад төрийн эрх баригчдаас аваад олон нийтийн зүтгэлтнүүд, эрдэмтэд хүртэл хувь нэмрээ оруулах ёстой.

Монголын академийн төлөөлөгчид АНУ-ын ЭЙСИЛСИ ба АЙРЕКС-тай хэлэлцээ хийж, шинжлэх ухааны зарим нэг сонирхсон салбарт эрдэмтэд солилцох, хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх тухай Протоколд гарын үсэг зурсан нь чухамдаа дээрх чигт үйлчлэх ёстой аж.

Протоколд гарын үсэг зурахад ШУА-ийн ерөнхийлөгч, академич Н. Содном үг хэлэхдээ БНМАУ, АНУ-ын эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд хэлхээ холбоо тогтоох тухай баримт бичигт гарын үсэг зурж байгаа явдал тус хоёр орны шинжлэх ухаан, соёл боловсролын талбарт хамтран ажиллахад сайхан эхлэлт тавьж байна, хойшид энэ салбарт арай өргөн хэмжээний хэлэлцээр байгуулагдах нь мэдээж гээд, энэ бол монгол, америкийн ард түмний харилцан ойлголцож итгэлцэх, найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгт тус нэмэр болохыг ерөөлөө. Доктор С. Катц хариу хэлсэн үгэндээ бид монголын эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэдтэй хэлхээ холбоо тогтоох гэж арав гаруй жил оролдож, сая энэхүү чармайлт маань хэрэгжиж, одоо бид америк, монголын хамтын ажиллагааны Протоколд гарын үсэг зурж байгаад их баяртай байна гэж илэрхийлэв.

Энэ Протокол байгуулагдсанаар БНМАУ, АНУ-ын шинжлэх ухааны талбарт гарсан ололт амжилттай харилцан танилцах, туршлага солилцох, эрдэмтдийг харилцан явуулж сонирхсон сэдвээр ажиллуулж байх, хамтарсан судалгаа хийж, хамтын ажиллагааг тогтоон өргөжүүлэх бололцоо нээгдэх юм. Тухайлбал, нийгмийн ухааны талбарт Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүйн асуудлаар одоо явагдаж байгаа монгол, америкийн эрдэмтдийн бага хурлыг үргэлжлүүлэхийн хамт, харилцан эрдэмтэд явуулж, лекц уншуулах, түүх, эдийн засаг, археологи, этнографийн гэхчилэн сэдвээр хамтран ажиллаж байх хэлбэрийг хэрэглэж болох талтай. Байгалийн шинжлэх ухааны хувьд гэвэл, биотехнологи, палеонтологи, антропологи, физикийн тодорхой асуудал, тухайлбал, нар салхины энерги, ТБМ, компьютер ашиглах талаар хамтын ажиллагааг өрнүүлж болох байна. Ийм санал хүсэлттэй байгаагаа бидний очсон эрдэм шинжилгээний газруудын ажилтнууд дэлгэрэнгүй ярьж, өөрсдийн хийж буй ажлаа аль болохоор тодорхой танилцуулж байлаа.

Бид Нью-Йоркийн Байгалийн түүхийн америкийн музей, Вашингтоны Смитсоны иж бүрэн байгууллагын харьяа Байгалийн түүхийн үндэсний музейгээр орвол манай дэлхийн хүн амьтны үүсэл гарлыг нарийн дэс дараатай улируулан харуулсан үзэсгэлэнт сайхан үзмэрүүд тавьсан нь үнэнхүү бахдалтай ажээ. Аль аль музейд нь Америкаас олдсон асар том динозаврын араг ясыг хэд хэдийг тавьсан байх нь сүртэй харагдана. Ди-

нозаврын араг яс манай Ваймонг зэрэг муж улсаас элбэг олддог, энэ муж танай Монголын говьтой адил элсэн цөлөрхүү, хад чулуутай газар гэж музейнийхэн ярьж байлаа. Байгалийн түүхийн америкийн музейн сээр нуруутны палеонтологийн тасгийн эрхлэгч Новачек ярихдаа танай Монголоос америкийн Эндрюсийн шинжилгээний ангийн 1920-иод онд олсон жижиг динозаврын араг яс манай музейг анхлан чимэглэсэн гэж үзвэл болно. Бид танай мэргэжилтнүүдтэй хэлхээ холбоо тогтоон, палеонтологийн салбарт хамтран ажиллаж, хамтарсан шинжилгээний анги зохион явуулахад бэлхэн байна гэжээ. Вашингтоны Байгалийн түүхийн үндэс ний музейд динозавраас гадна олон сайхан үзмэрүүд байгаагаас бүхэл бүтэн ханан дэлгэцнээ Америкийн эртний хүмүүсийн амьдралыг харуулсан өнгөт стерео кино гаргахад үзэгчдэд уул үйл явдалд биеэр оролцож тэр шөнө дунд зэрлэг хүмүүстэй түүдэг гал түлж тойрон сууж мах шарж байгаа мэт сэтгэгдэл төрөх ажээ.

Нью-Йорк дахь Азийн нийгэмлэгт зохиосон уулзалтанд оролцож, түүний дэд ерөнхийлөгч Маршал М. Бүтон мөн Беатэ Гордон авхай нартай ярилцахад үүний өмнө танай монголын урлагийн хэсгийг урлаг судлаач, эрдэмтэн Ж. Бадраа толгойлон ирж, америкийн олон нийтэд сонирхуулсан нь онцгой амжилттай боллоо, бид танай улстай соёлын өргөн харилцаа тогтоох сонирхолтой байна гэж санал тавьж билээ.

Бидний сэтгэгдэлд үлдсэн өөр нэг чухал үйл явдал гэвэл Вашингтонд дунд ба ойр тусгалын пуужинг устгах тухай Зөвлөлт-америкийн гэрээг батлах эсэх асуудлыг АНУ-ын Конгрессын Сенатын хуралдаанаар хэлэлцэж байхыг танхимд нь орж биеэр үзлээ. Энд АНУ-ын төрийн бодлого боловсрогддог ажээ.

Манай Монголд үүний өмнө айлчилсан сенатор Алан Крэнстон монголын төлөөлөгчид биднийг өөрийн албан өрөөндөө найрсагаар хүлээн авч, Сенатын үйл ажиллагааны тухай товч танилцуулж, Сенатын хуралдаанд дагуулан оруулж уул асуудал хэлэлцэж байхыг сонирхуулсан билээ. Тэр хуралдаан дээр Сенатын харгис жигүүрийн нэг толгойлогч сенатор Хэлмс дунд ба ойр тусгалын пуужинг устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээг батлахгүй, тэрхүү гэрээнд, америкийн улс төрийн шинэ хэллэгээр, «алах засвар» оруулахыг оролдолхийлж, ширүүн маргалдаж байхыг нүдээр үзлээ. Энэ мэтээр Сенатын оппозиц хүчин хэдхэн хоногийн дараахан Москвад болох гэж байсан Зөвлөлт-Америкийн дээд хэмжээний Горбачев-Рейганы уулзалтыг угтуулан саад тотгор хийхийг санаархаж байжээ. Бид А. Крэнстоноос таны бодоход Зөвлөлт-америкийн гэрээг ямаршуухан харьцаатай танай Сенат батлах бол, эсгүүл батлахгүй юу гэж асуухад, тэрээр 4—10 орчим сенатор татгалзаж, гэрээ олон хийн саналаар батлагдана гэж итгэж байна гэв. Тэр ч ёсоор дунд ба ойр тусгалын пуужинг устгах тухай Зөвлөлт-америкийн гэрээ АНУ-ын Сенат 93:5-ын харьцаатай баталсан тухай «Вашингтон пост» сонинд маргааш нь 1988 оны 5-р сарын 28-нд тэргүүн нүүрэнд нийтэлсэн байхыг бид үзэж, сенатор Крэнстоны таавар үнэн болохыг ойлгов. Тэр сонинд бичихдээ «Сенат дунд ба ойр тусгалын пуужинг устгах түүхэн гэрээг сайшаав» гэжээ. Цааш нь Рейган, Горбачев нар дараа долоо хоногт Москвагийн дээд хэмжээний уулзалтаар энэ гэрээг батлах гэж байна гэж том үсгээр гарчиглан нийтэлсэн байв. Мөн сонинд Зөвлөлт-америкийн гэрээг баталсан хэсэг сенаторын зургийг тавьсаны дотор А. Крэнстон байв. Сенат хуралдаж байх үеэр их завсарлагаар сенатор А. Крэнстон биднийг дагуулж, Конгрессын хоолны газар урьж дайлсан билээ. Тэнд голдуу негр бүсгүйчүүд хурдан шаламгай үйлчилж, төрөл бүрийн идээ

ундааны алийг таалах вэ гэж мэхэсхийн асуух ажээ. Биднийг зоог барьж байхад, Крэнстон найр тавьж, Р. Доул, Р. Бирд зэрэг сенаторуудтай танилцуулахад тэд монголын академийн төлөөлөгчид бидэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлж билээ.

(Үргэлжлэл бий).

ШАНДУ ХОТЫН ТУУРИЙГ ҮЗСЭН НЬ

Ч. ДАЛАЙ

Түүхийн ухааны доктор

Юан гүрний үеийн монгол хаадын зуслан хэмээн алдаршсан Шанду хотын туурийг үзэхээр Шилийн хотоос шулуун хөх хошууны төв орохоор гарлаа. ӨМӨЗО-ны гадаад харилцааны газрын ажилтан Алтанбагана, Шилийн хотын гадаад харилцааны газрын ажилтан Лю нар Зоригт бид хоёрыг дагалдан явлаа. Цэлмэг сайхан өдөр байлаа. Тэр зүг чиглэсэн засмал замаар бидний суусан тэрэг 70 орчим миллийн хурдтай давхиж байв. Замын хажуугаар бут сөөг ургасан довтолгод, бүрд, шанд хосолсон говь хээр нутаг үргэлжилнэ. Юан гүрний үеэс Монгол хаад ноёдын сүргийг маллаж онд тарган оруулдаг хайлаас, тоорой, сухай, бөөргөлжин буйлс зэрэг говийн ой шугуй бүхий Баян-бүрд байдгийг сонссон, Газрын талд ороход тэрхүү Баянбүрд үргэлжлэв. Одоогийн байдлаар эртнийхээ дүр төрхийг алдаж мод нь сийрэгжиж элсэнд идэгдэж байгаа байдалтай харагдав.

Дөрвөн цаг хагас хиртэй явж Шулуун Хөх хошууны төвд ирж зочид буудалд байрлав. Хошууны дарга Дамба, соёлын танхимын эрхлэгч Чимид, «Шандын ундрал» сэтгүүлийн эрхлэгч Чимгээ, буудлын орлогч дарга Хас болон Чингэс товчоон номын зохиогч нэрт түүхчин Сайшаал нар угтан учрав. Тэр оройжингоо монголын түүхийн сонирхолтой сэдэв, газар орны талаар хууч ярилцахад аян замын алжаалыг нэгэнт мартаж, харин монголчууд мөн ч урт удаан хугацааны баялаг сайхан түүхтэй үндэстэн юм даа гэдэг бодол зүрх сэтгэлийг минь байнга эзэмдэх байв. Тэр нутагт төрж өссөн түүхчин Сайшаал гуай монголын түүхийн газар орны талаар нэлээд зүйл тайлбарлан ярив. Мөн ч их юм үзсэн, ой ухаан сайтай хүн болох нь мэдэгдэж байв.

Бидний очсон шөнө зөөлөн бороо оров. Маргааш нь цэлмэг сайхан өдөр байлаа. Энэ бол тавдугаар сарын 24-ний өдөр юм. Өглөө 9 цагт Шанду хотын туурь үзэхээр гурван тэргэнд хуваагдан сууж хөдөлцгөөв. Өргөн уудам Шанду-гийн шар талаар давхихад энд тэндгүй үхэр мал идээшилж байв. Адуу, үхэр, хонь малын бэлчээрт тохиромжтой байрын нутаг юм. Урт нарийхан Шанд гол нь 108 булгаас эх авдаг гэж нутгийн настнууд ярьдаг ажээ. Шандугийн шар тал 70 км үргэлжилдэг юм байна. Намар цагт шар цэцгээр битүү хучигддаг гэнэ. Иймээс түүхэнд